



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 22 өдөр

Дугаар А/612

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 08 дугаар сарын 05-ны 4/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Гурван сэнхэр төвтэй 5 од аялал жуулчлал”-ын хөтөлбөрийн хүрээнд “Ховдын тарвас” эвент арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг болгон 10.0 сая төгрөгийг зарцуулсугай.


2. Дээрхи арга хэмжээнд зарцуулах 10.0 сая төгрөг /арван сая/-ийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний жагсаалтын 4.19-д тусгагдсан хөтөлбөр арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2021 оны
10 дугаар сарын 22-ны өдрийн
А/612 дугаар захирамжийн
хавсралт

ТӨСВИЙН ЗАДАРГАА

№	Нэр	Хариуцах эзэн	Тоо хэмжээ	Нэгж	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	Мөнгөн шагнал	Хүнс. Хөдөө аж ахуйн газар	5	ш	100000	500 000
2	Өргөмжлөл	Хүнс. Хөдөө аж ахуйн газар	5	ш	25000	125 000
3	Анонс	Засаг даргын Тамгын газар	30	м2	12000	360 000
4	Зочид буудал /4хоног*10/	Аялал зочид буудлын холбоо	4	хоног	75000	3 000 000
5	Хонь	Аялал зочид буудлын холбоо	2	ш	140000	280 000
6	Мэргэжилтнүүдийн ажлын хөлс	Аялал зочид буудлын холбоо	10		500000	5 000 000
7	Хоолны материал	Аялал зочид буудлын холбоо	1,00		735000	735 000
Нийт						10 000 000